


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

08.17 - 08.21



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй хаагдлаа. S&P 500 индекс 2-р сарын хамгийн дээд түвшиндээ хүрэхэд 126 арилжааны өдөр шаардсан нь сэргэхэд шаардлагатай түүхэн дундаж хугацаа буюу 1,542 арилжааны өдрөөс 10 дахин бага байсан нь түүхэн үзүүлэлт болсон байна.

S&P 500 индексийн сагсанд багтах "Google" компанийн толгой компани "Alphabet" компанийн хувьцааны ханш өссөнтэй холбоотой харилцаа холбооны салбар хамгийн их өсөлттэй байлаа. Чип үйлдвэрлэгч Nvidia болон зах зээлийн үнэлгээгээрээ 2 их наяд давсан анхны АНУ-ын олон нийтэд нээлттэй компани болсон Apple компанийн хувьцааны ханшийн өсөлтөөс үүдэн технологийн салбар мөн өсөлттэй байлаа. Харин, ОПЕК болон бусад голлох hydrocarbon үйлдвэрлэгч улсууд дэлхийн тосны эрэлт удаан сэргэнэ гэсэн хүлээлттэй байгаатай холбоотойгоор эрчим хүчний салбар хамгийн их уналттай байлаа. Warren Buffett-ийн Berkshire Hathaway компани банкны салбарт эзэмшиж буй хувьцаагаа их хэмжээгээр бууруулж байгаатай холбоотой санхүүгийн салбар мөн бууралттай байлаа.

Европ: АНУ болон БНХАУ-ын таагүй харилцаа болон халдварын дараагийн давалгаа эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлээс үүдэн Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд бууралттай байлаа. STOXX Европ 600 индекс 0.81%-аар, Xetra DAX индекс 1.06%-аар, FTSE MIB индекс 1.66%-аар, FTSE 100 индекс 1.45%-аар тус тус буурсан байна.

АНУ-ын Түүхий эдийн Фьючерс Худалдааны Комиссын мэдээлснээр, евро фьючерсийн цэвэр урт позиц /net long position/ энэ долоо хоногт дээд түвшинд хүрсэн буюу 30 тэрбум ам.доллар хүрсэн байна. Энэ долоо хоногт еврогийн ам.доллартой харьцах ханш 2018 оны 5 сараас хойших хамгийн дээд хэмжээнд хүрсэн ба энэ нь коронавирусын хөл хорионы нөлөөллөөс Европ бүсийн эдийн засаг АНУ-тай харьцуулахад хурдан сэргэх магадлалтай байгаатай холбоотой.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индекс уналттай байлаа. Япон улсын эрх баригчид 2020 оны 6-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон эхний санхүүгийн улирлын ДНБ-ийн урьдчилсан тооцоог гаргажээ. Эрх баригчдын мэдээлж байгаагаар, дэлхий дахинд нүүрлээд буй цар тахлын нөлөөллийн улмаас Японы эдийн засаг түүхэн дээд хэмжээгээр агшсан байна. ДНБ 1-р улиралд 7.8%-аар буурсан ба энэ нь экспорт болон хэрэглээний огцом бууралттай холбоотой аж.

БНХАУ: Ерөнхийлөгч Доналд Трамп сүүлийн 6 сарын худалдааны хэлэлцүүлгийн товыг хойшлуулан АНУ болон БНХАУ-ын муудаж буй харилцааны талаарх зовнилыг намдааснаар БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд бага зэрэг өсөлттэй хаагджээ. Зарим ажиглагчид Цагаан ордноос БНХАУ-д фермийн бүтээгдэхүүнүүд болон бусад төрлийн экспортын худалдан авалтаа өсгөх боломж олгож, худалдааны хэлэлцээрийг эерэг харагдуулахын тулд энэхүү арга хэмжээг авсан гэж үзэж байна. Гэхдээ АНУ-аас Huawei Technologies компанид нэмэлт хориг тавихаа зарласан нь хоёр улсын хоорондын харилцаанд сөргөөр нөлөөлсөөр байгаа юм.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,057.89	3.72% ▲
Dow Jones	АНУ	27,930.33	0.00% ▼
S&P 500	АНУ	3,397.16	0.72% ▲
Nasdaq	АНУ	11,311.80	2.65% ▲
S&P/TSX	Канад	16,517.85	0.02% ▲
FTSE 100	Их Британи	6,001.89	-1.45% ▼
S&P/ASX 200	Австрали	6,111.20	-0.24% ▼
Nikkei 225	Япон	22,920.30	-1.58% ▲
Hang Seng	Хонг Конг	25,113.84	-0.27% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.68
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.55
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.32
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.45
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.65
DBM' 2023	USD	7.250%	104.31
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	96.15

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.175	0.16 ▲
Libor 3M	0.250	-0.08 ▼
Libor 6M	0.314	-0.05 ▼
Libor 1YR	0.441	-0.04 ▼
US 2YR Bond	0.143	-0.01 ▼
US 3YR Bond	0.162	-0.10 ▼
US 5YR Bond	0.263	-0.10 ▼
US 10YR Bond	0.627	-0.11 ▼

Валютын ханш	2020.08.21	Өөрчлөлт
USD	2,850.89	0.10% ▲
CNY	412.51	0.63% ▲
EUR	3,375.03	0.41% ▲
RUB	38.48	-0.98% ▼
KRW	2.4	0.00%
JPY	27.02	1.27% ▲
CAD	2,162.55	0.51% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,940.48	-0.24% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	26.79	1.30% ▲
Зэс	USD/lb.	293.40	1.80% ▲
Нүүрс	USD/MT	51.35	-4.52% ▼
WTI газрын тос	USD/bbl.	42.34	0.79% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.28	-5.62% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.45	3.81% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VII	3.40%
Бодлогын хүү	2020.VII	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VII	8.85%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VII	10.91%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VII	4.24%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VII	16.89%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VII	10.45%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 61 компанийн 709.9 сая төгрөгийн 7,778,889 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Улсын их дэлгүүр” /MSE: UID/ компанийн хувьцаа 33.44%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,201.00 төгрөг хүрч хаагдсан бол “Баянгол зочид буудал” /MSE: BNG/ компанийн хувьцаа 23.95%-аар буурч 25,020.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 11.3 сая төгрөгийн 113 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

8-р сарын 21-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,599.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,057.89 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.72%-аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	113	11,300,000	100,000	100,000	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	721.1	
Зах зээлийн үнэлгээ	2,599,220.7	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,057.89	3.72% ▲
MSE I индекс	8,315.25	2.46% ▲
MSE II индекс	7,338.47	-0.95% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Женко тур брью	2,631,582	250,000,290
Лэндмн ББСБ	4,170,465	131,249,859
АПУ	198,305	116,038,794
Эрдэнэ ресурс девелопмент корп	65,918	65,903,512
Ард санхүүгийн нэгдэл	41,125	45,222,457

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	1,201.00	33.44% ▲
Дархан зочид буудал	146.60	14.98% ▲
Монгол цахилгаан холбоо	376.01	14.33% ▲
Гермес центр	130.00	10.30% ▲
Стандарт агригалчер групп	75.00	10.29% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Баянгол зочид буудал	25,020.00	-23.95% ▼
Монгол савхи	550.00	-14.72% ▼
Женко тур брью	76.00	-14.60% ▼
Нийслэл өргөө	2,600.00	-13.33% ▼
Дархан хөвөн	7,000.00	-12.50% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	614,991,250
Мирэ Эссет Секьюритис Монгол	210,308,090
Ард Секьюритиз	121,738,631
Апекс Капитал	78,646,629
Гаули	73,584,247

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	549.00	584,235.67
Таван толгой	5,595.00	294,661.79
МИК холдинг	12,990.00	269,014.07
Инвекор ББСБ	2,650.00	190,078.98
Говь	194.22	151,513.45

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

МХБ-ийн хувьцааны II ангилалд бүртгэлтэй “Женко тур брюо” /MSE: JTB/ ХК-ийн хувьцааг 8-р сарын 21-ны өдөр багцаар арилжаалсан байна.

Энэ удаагийн арилжаагаар компанийн 2.6 сая ширхэг хувьцаа буюу нийт хувьцааны 2.63%-ийг 250.0 сая төгрөгөөр буюу нэгж хувьцааг 95.00 төгрөгөөр арилжаалжээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“АПУ” /MSE: APU/ ХК хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна

“АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 8-р сарын 13-ны өдрийн хурлын 20/14 тоот тогтоолоор компанийн хагас жилийн санхүүгийн үр дүнг харгалзан нэгж хувьцаанд 37.5 төгрөг, нийт 39.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулагдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэлийн өдрөөр тогтоох бөгөөд 2021 оны 2-р сарын 10-ны өдөрт багтаан тараахаар болсон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“АПУ” /MSE: APU/ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал болно

“АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 8-р сарын 13-ны өдрийн 20/15 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулахаар болсон байна.

Саналын хуудас хүлээн авах хугацаа: 2020 оны 8-р сарын 21-ний өдрөөс 2020 оны 10-р сарын 2-ны өдрийн 16.00 цаг хүртэл.

Саналын хуудас хүлээн авах газар: “БиДиСек ҮЦК” /MSE: BDS/ ХК эсвэл хувьцаа эзэмшигчийн харилцдаг үнэт цаасны компани.

Бүртгэлийн өдөр: 2020 оны 9-р сарын 2-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- “АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;
- “АПУ” /MSE: APU/ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (кумулятив аргаар сонгогдох 9 гишүүн)-ийг сонгох

Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн: Хурал зохион байгуулах комиссын Дарга: Ч.Ариунсан, Гишүүн: Э.Солонго, Б.Мягмар

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Хар хорум пропертийс” /MSE: AMT/ ХК-ийн оноосон нэрийг “Эрдэнэс сольюшинс” /MSE: AMT/ ХК болгон өөрчиллөө.

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй “Хар хорум пропертийс” /MSE: AMT/ ХК-ийн 2020 оны 1-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар тус компанийн нэрийг өөрчилж, дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Монголын Хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 2-р сарын 19-ний өдрийн А/16 тоот тушаал болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2020 оны 8-р сарын 14-ний өдрийн тушаалаар “Хар хорум пропертийс” /MSE: AMT/ ХК-ийн оноосон нэрийг “Эрдэнэс сольюшинс” /MSE: AMT/ ХК болгон өөрчлөлт орууллаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК-аас ирүүлсэн мэдээлэл.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /TSX: ERD, MSE: ERDN/ ХК нь Хөндий Алтны дүүрэг дахь тусгай зөвшөөрлийн талбайд томоохон өрөмдлөгийн хөтөлбөр эхлүүлээ.

Баян Хөндийд хийгдэж эхэлсэн энэхүү хөтөлбөрөөр нийт 18,000 метр өрөмдлөгийг он дуусахаас өмнө гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд ирэх долоо хоногоос Хар Морь талбайд хоёрдугаар өрөмдлөгийн багыг ажиллуулж эхлэхээр болсон байна. Энэхүү хөтөлбөр нь дүүргийн шинэ талбайнуудыг шалгах, одоогийн ордуудтай зэрэгцээ орших талбайд нөөц нэмэгдүүлэх, одоогийн нөөцийн талбайг бататгах, цаашид Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх зорилго тавиад байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Банкны салбар нь харилцагч, хадгаламж эзэмшигчдийн итгэлцэл дээр тогтдог маш эмзэг салбар бөгөөд аливаа хэлбэрээр олон нийтэд цацагдаж, түгсэн буруу ташаа мэдээлэл нь тухайн банкны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, банкнийг эрсдэлд оруулах улмаар эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх томоохон эрсдэл, сөрөг үр дагавартай.

Өнөөдрийн байдлаар системийн ач холбогдол бүхий 5 том банк үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт Нийгмийн даатгалын 899.7 тэрбум төгрөг байршиж, иргэд, харилцагчдад тэтгэвэр халамжийн үйлчилгээг үзүүлж байна. Дэлхий дахинд нүүрлээд байгаа цар тахалтай холбоотойгоор арилжааны банкнууд ч мөн эдийн засгийн амаргүй орчинд үйл ажиллагаа явуулж байгаа боловч 2020 оны 8-р сарын 18-ны өдөр олон нийтэд мэдээлэгдсэн арилжааны томоохон 2 банканд эрсдэл үүссэн гэх мэдээлэл нь бодит байдалд нийцээгүй болохыг мэдэгдье.

Банкны тухай хуульд заасны дагуу одоогоор үйл ажиллагаа явуулж буй бүх банк сар бүрийн санхүүгийн тайлан мэдээ, Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэрхэн ханган ажиллаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтмол олон нийтэд мэдээлдэг тул өөрийн харилцагч банкны мэдээллийг нягтлах, судлах бүрэн боломжтой юм.

Эх сурвалж: Монголбанк

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилсан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32-р тогтоолоор чиглэл болгосон банкны зээлийн хүү болон зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах төслийг УИХ-ын гишүүн Д.Баттөмөрөөр ахлуулсан ажлын хэсгийн гишүүд УИХ-ын дарга Г.Занданшатарг өргөн барилаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25-р зүйлд заасан бүрэн эрхийн дагуу Улсын Их Хурлаас цар тахлын нөлөөллөөр хумигдаад байгаа санхүүгийн хүртээмж, зуучлалыг зээлийн хүү өндөр байгаагийн улмаас зогсонги байдалд хүргэхээс сэргийлэх үүднээс түүнд нөлөөлж байгаа хүчин зүйл, шалтгаант холбоог тодорхойлсон судалгааны үр дүнд

тулгуурлаж зээлийн хүүг бууруулах стратеги хэрэгжүүлэх нь нэн тэргүүний ажил болоод байна. Сүүлийн жилд банкны салбарын зээлийн хүү 4 нэгж хувиар тогтвортой буурч 2020 оны 6-р сарын эцсийн байдлаар жигнэсэн дундаж хүү жилийн 16.3 хувь болсон. Гэсэн ч тулгамдсан асуудлын нэг хэвээр байгаа тул эдийн засгийг төрөлжүүлэх, бизнесийн хөрөнгө оруулалт хийх, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихүйц түвшинд зээлийн хүүг дорвитой бууруулах шаардлагатай байна. Тиймээс зээлийн хүүг бууруулахад санхүү, эдийн засгийн бодлого болоод хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлснээр Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэх болно.

Эх сурвалж: Монголбанк

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улс 2020 оны эхний хагас жилд нийт 135 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.3 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 2.8 тэрбум ам.доллар, импорт 2.5 тэрбум америк доллар боллоо. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.5 (22.6%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.1 (28.2%) тэрбум америк доллароор, импорт 433.7 (15.0%) сая америк доллароор тус тус буурчээ. Харин 2020 оны 6-р сард экспорт 822.1 сая америк доллар, импорт 467.7 сая америк доллар болж, өмнөх сараас экспорт 189.4 (29.9%) сая америк доллароор, импорт 61.6 (15.2%) сая америк доллароор тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний хагас жилд 1.0 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 677.0 сая америк

доллароор буурч, 368.2 сая америк долларын ашигтай байна.

Манай 2 хөрш улс нь гадаад худалдааны нийт эргэлтэд хамгийн өндөр дүнг эзэлж, БНХАУ-тай 3.0 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.2 хувийг эзэлж байна. БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 74.7 хувийг бүрдүүлж байна. БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 31.2 хувийг чулуун нүүрс, 35.1 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.8 хувийг, Сингапур улсад экспортолсон барааны 80.2 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 68.6 хувийг алтны экспорт эзэлж байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

БАРИЛГА УГСРАЛТ БОЛОН БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР

МХБ-ийн I, II ангилалд бүртгэлтэй 60 хувьцаат компаниас 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангаа МХБ-ын цахим хуудсанд байршуулсан Барилга угсралт болон барилгын материал үйлдвэрлэлийн салбарын 5 компанийн санхүүгийн үзүүлэлтийг доорх зургаар үзүүллээ.


2020 оны эхний хагас жилд тус компаниуд нийт 28.07 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 133.5%-аар их байгаа бөгөөд нийт цэвэр ашиг 4.06 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 664.8%-аар өссөн үзүүлэлт болсон байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг харвал тус компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 174.10 тэрбум төгрөг хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 70.4%-аар өссөн үзүүлэлт болсон бол нийт эздийн өмчийн хэмжээ 74.89 тэрбум төгрөг хүрч өмнөх оны мөн үеэс 9.0%-аар өссөн байна.

Барилга угсралт болон барилгын материал үйлдвэрлэлийн салбарын санхүүгийн үзүүлэлтүүдэд “УБ-БУК” /MSE: BUK/ ХК хамгийн ихээр нөлөөлсөн байна.

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО


тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЦЭВЭР АШИГ


тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

НИЙТ ХӨРӨНГӨ


тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЭЗДИЙН ӨМЧ

тэрбум төгрөг



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.